ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн 24 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ОРА-2021/92/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Орхон аймаг
2021 он

Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас:70359826
Цахим хаяг:orkhon@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас:70355805
Цахим хаяг:erdeneb@audit.gov.mn
Аудитор: Б.Бямбатогтох
Утас:70350757
Цахим хаяг:byambatogtokhb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ХАА | Хөдөө аж ахуй |
| БҮТЭЗ | Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ..... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..... 13
3. Аудитын тайлан ..... 14
3.1. Ерөнхий зүйл ..... 14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..... 14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ..... 15
3.4. Материаллаг байдал ..... 15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ..... 16
3.7. Шилэн дансны мэдээлэл ..... 17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 17
3.9. Аудитын илрүүлэлт ..... 17
Залруулсан алдаа ..... 17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ..... 17
Аудитын зөвлөмж ..... 18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ..... 18
4. Менежментийн захидал ..... 19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ..... 21

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.02.25 № 65

танай______________-ны № _______________-т

ОРХОН АЙМГИЙН 24-Р
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ж.ДАВААСҮРЭН ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн 24-р цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн 24-р цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

D:\my doc \albanbichig\ 2021-A4.doc

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **80,065,037.82** | **81,629,147.82** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 438,300.00 | 338,300.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 438,300.00 | 338,300.00 |
| **3121** | **Төгрөг** | 438,300.00 | 338,300.00 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 438,300.00 | 338,300.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 79,626,737.82 | 81,290,847.82 |
| **351** | **Түүхий эд материал** | 74,417,177.82 | 76,750,877.82 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 74,417,177.82 | 76,750,877.82 |
| **354** | **Хангамжийн материал** | 5,209,560.00 | 4,539,970.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 515,200.00 | 820,250.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,565,030.00 | 3,340,680.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,129,330.00 | 379,040.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **958,615,641.77** | **938,420,418.81** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 958,615,641.77 | 938,420,418.81 |
| **392** | **Биет хөрөнгө** | 846,385,641.81 | 826,240,418.89 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 825,501,320.32 | 825,501,320.32 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (16,604,398.41) | (33,434,942.25) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 36,586,947.35 | 41,835,447.35 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (23,949,703.18) | (27,950,378.22) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 38,754,409.70 | 38,754,409.70 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (23,322,480.84) | (27,161,921.88) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 10,142,609.87 | 10,142,609.87 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (723,063.00) | (1,446,126.00) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 112,229,999.96 | 112,179,999.92 |
| 39301 | Програм хангамж | 880,000.00 | 400,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (530,000.04) | (100,000.08) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 111,880,000.00 | 111,880,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,038,680,679.59** | **1,020,049,566.63** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,038,680,679.59** | **1,020,049,566.63** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,038,680,679.59 | 1,020,049,566.63 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 618,529,516.00 | 618,529,516.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 618,529,516.00 | 618,529,516.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 54,126,403.11 | 35,495,290.15 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 54,126,403.11 | 54,126,403.11 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (18,631,112.96) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 366,024,760.48 | 366,024,760.48 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,038,680,679.59** | **1,020,049,566.63** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **455,425,003.00** | **434,503,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **35,803,903.00** | **8,121,900.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 35,803,903.00 | 8,121,900.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 35,803,903.00 | 8,121,900.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 35,803,903.00 | 8,121,900.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **419,621,100.00** | **426,381,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 353,249,200.00 | 404,609,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 353,249,200.00 | 404,609,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 48,282,100.00 | - |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 175,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 48,107,100.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 18,089,800.00 | 21,772,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 18,089,800.00 | 21,772,200.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **443,421,393.47** | **452,559,502.96** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **443,421,393.47** | **452,559,502.96** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 442,594,232.47 | 442,567,762.96 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 298,210,639.00 | 329,471,400.00 |
| 210101 | Үндсэн цалин | 272,420,871.00 | 302,603,467.00 |
| 210102 | Нэмэгдэл | - | 11,538,716.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 102,514.00 |
| 210104 | Урамшуулал | 25,789,768.00 | 15,226,703.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37,325,200.00 | 43,077,214.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,820,300.00 | 29,898,914.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,626,100.00 | 3,294,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,100,900.00 | 2,635,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 525,200.00 | 658,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,252,700.00 | 6,589,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16,704,500.00 | 11,857,056.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,095,192.00 | 3,056,124.00 |
| 210302 | Түлш, халаалт | 5,309,606.00 | 5,490,555.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,299,702.00 | 3,310,377.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,244,373.88 | 8,087,050.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 916,900.00 | 271,450.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 279,930.00 | 170,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 130,090.00 | 2,707,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,700,530.00 | 4,937,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210408 | Бараа материал акталсны зардал | 2,216,923.88 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 55,644,620.00 | 21,412,770.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 33,930.00 | 64,750.00 |
| 210502 | Хоол, хүнс | 55,266,390.00 | 21,193,020.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 344,300.00 | 155,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 535,000.00 | 316,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 535,000.00 | 316,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 131,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 131,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,337,780.00 | 705,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 857,780.00 | 705,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 480,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 24,592,119.59 | 27,509,372.96 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 205,300.00 | 200,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 950,050.00 | 1,865,650.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 23,436,769.59 | 25,443,722.96 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 827,161.00 | 9,991,740.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 420,700.00 | 250,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 420,700.00 | 250,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 406,461.00 | 208,660.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 406,461.00 | 208,660.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 9,533,080.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 9,533,080.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **12,003,609.53** | **(18,055,902.96)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 575,210.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | - | 575,210.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (575,210.00) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **12,003,609.53** | **(18,631,112.96)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **431,358,596.00** | **427,393,376.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **431,358,596.00** | **427,393,376.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 353,249,200.00 | 404,609,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 353,249,200.00 | 404,609,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 48,692,100.00 | - |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 175,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 48,517,100.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 18,089,800.00 | 21,772,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 18,089,800.00 | 21,772,200.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 11,327,496.00 | 1,011,676.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 11,327,496.00 | 1,011,676.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **431,378,596.00** | **427,493,376.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **431,378,596.00** | **427,493,376.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **418,924,639.00** | **416,489,960.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 298,210,639.00 | 329,471,400.00 |
| 210101 | Үндсэн цалин | 280,729,120.00 | 302,603,467.00 |
| 210102 | Нэмэгдэл | - | 11,538,716.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 102,514.00 |
| 210104 | Урамшуулал | 17,481,519.00 | 15,226,703.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37,325,200.00 | 43,077,214.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,820,300.00 | 29,898,914.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,626,100.00 | 3,294,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,100,900.00 | 2,635,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 525,200.00 | 658,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,252,700.00 | 6,589,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16,704,500.00 | 11,857,056.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,095,192.00 | 3,056,124.00 |
| 210302 | Түлш, халаалт | 5,309,606.00 | 5,490,555.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,299,702.00 | 3,310,377.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,732,400.00 | 6,565,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 449,150.00 | 129,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 279,930.00 | 170,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 80,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 130,090.00 | 5,953,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 873,230.00 | 232,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 59,122,620.00 | 21,898,740.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 37,000.00 | 169,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 56,250,420.00 | 21,017,940.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,835,200.00 | 711,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,570,300.00 | 316,100.00 |
| 210602 | Тавилга | 175,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 1,395,300.00 | 316,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 131,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 131,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,337,880.00 | 705,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 857,780.00 | 705,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 480,100.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,921,100.00 | 2,467,050.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 306,000.00 | 200,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,615,100.00 | 2,267,050.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **12,453,957.00** | **11,003,416.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 12,047,496.00 | 1,261,676.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 11,327,496.00 | - |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | - | 1,011,676.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 720,000.00 | 250,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 406,461.00 | 208,660.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 406,461.00 | 208,660.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 9,533,080.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 9,533,080.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(20,000.00)** | **(100,000.00)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **400,000.00** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **400,000.00** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 400,000.00 | - |
| 223001 | Бусад хөрөнгө | 400,000.00 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(400,000.00)** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (420,000.00) | (100,000.00) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 858,300.00 | 438,300.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 438,300.00 | 338,300.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 618,529,516.00 | 366,024,760.48 | 41,778,493.58 | | 1,026,332,770.06 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **618,529,516.00** | **366,024,760.48** | **41,778,493.58** | **-** | 1,026,332,770.06 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 12,347,909.53 | | 12,347,909.53 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **618,529,516.00** | **366,024,760.48** | **54,126,403.11** | **-** | 1,038,680,679.59 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **618,529,516.00** | **366,024,760.48** | **54,126,403.11** | **-** | 1,038,680,679.59 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **618,529,516.00** | **366,024,760.48** | **54,126,403.11** | **-** | 1,038,680,679.59 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (18,631,112.96) | | (18,631,112.96) |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **618,529,516.00** | **366,024,760.48** | **35,495,290.15** | **-** | 1,020,049,566.63 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 0.00 | 431372135.00 | 426381700.00 | 416639960.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 0.00 | 430972135.00 | 426381700.00 | 416639960.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 418924639.00 | 426231700.00 | 416489960.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 0.00 | 298210639.00 | 329471400.00 | 329471400.00 |
| 210101 | Үндсэн цалин | 0.00 | 280729120.00 | 213622600.00 | 302603467.00 |
| 210102 | Нэмэгдэл | 0.00 | 0.00 | 86599500.00 | 11538716.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 0.00 | 2480000.00 | 102514.00 |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 17481519.00 | 26769300.00 | 15226703.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 0.00 | 37325200.00 | 43077300.00 | 43077214.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 0.00 | 26820300.00 | 29898500.00 | 29898914.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 0.00 | 2626100.00 | 3294700.00 | 3294700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 0.00 | 2100900.00 | 2635800.00 | 2635300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 0.00 | 525200.00 | 658900.00 | 658900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 0.00 | 5252700.00 | 6589400.00 | 6589400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 0.00 | 16704500.00 | 20140500.00 | 11857056.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 0.00 | 5095192.00 | 5295900.00 | 3056124.00 |
| 210302 | Түлш, халаалт | 0.00 | 5309606.00 | 7283300.00 | 5490555.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 0.00 | 6299702.00 | 7561300.00 | 3310377.00 |
| 210304 | Байрны түрээс | | | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0.00 | 1732400.00 | 6565600.00 | 6565600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 0.00 | 449150.00 | 129000.00 | 129000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 279,930.00 | 170,500.00 | 170,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | - | 80,700.00 | 80,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 130,090.00 | 5,953,300.00 | 5,953,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 873,230.00 | 232,100.00 | 232,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 59,122,620.00 | 21,898,800.00 | 21,898,740.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 37,000.00 | 169,100.00 | 169,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 56,250,420.00 | 21,018,000.00 | 21,017,940.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 2,835,200.00 | 711,700.00 | 711,700.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 1,570,300.00 | 1,631,700.00 | 316,100.00 |
| 210602 | Тавилга | - | 175,000.00 | - | - |
| 210604 | Урсгал засвар | - | 1,395,300.00 | 1,631,700.00 | 316,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | - | 131,800.00 | 131,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | - | 131,800.00 | 131,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 1,337,880.00 | 705,000.00 | 705,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 857,780.00 | 705,000.00 | 705,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 480,100.00 | - | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 2,921,100.00 | 2,609,600.00 | 2,467,050.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 306,000.00 | 342,500.00 | 200,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 2,615,100.00 | 2,267,100.00 | 2,267,050.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 12,047,496.00 | 150,000.00 | 150,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 12,047,496.00 | 150,000.00 | 150,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | - | 11,327,496.00 | - | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 720,000.00 | 150,000.00 | 150,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **400,000.00** | **-** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 400,000.00 | - | - |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 400,000.00 | - | - |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 382,666,496.00 | 448,153,900.00 | 416,639,960.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | 353,249,200.00 | 426,381,700.00 | 404,400,540.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | - | 353,249,200.00 | 426,381,700.00 | 404,400,540.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | 18,089,800.00 | 21,772,200.00 | 12,239,420.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | - | 18,089,800.00 | 21,772,200.00 | 12,239,420.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | 11,327,496.00 | - | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | - | 11,327,496.00 | - | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **438,300.00** | | **-** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | - | - | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | - | - | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | - | - | 32 | 32 |
| 620001 | Удирдах ажилтан | - | - | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | - | - | 23 | 23 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | - | - | 8 | 8 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | - | - | 200 | 200 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | - | - | 200 | 200 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | - | - | 200 | 200 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **-** | **-** | **32** | **32** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | - | - | 19 | 19 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | - | - | 1 | 1 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | - | - | 12 | 12 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(Төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **100,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **100,000.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 100,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 100,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 100,000.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 438,300.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 438,300.00 | 338,300.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд 24 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг 24 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Ж.Даваасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын  аудитор Б.Бямбатогтох хариуцаж хэрэгжүүлэв.

24 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 18-ний өдрийн 04 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

24 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Сургуулийн өмнөх боловсрол нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино.

***ЗОРИЛГО:*** Сургалтын байгууллагын үйл ажиллагааг сайжруулан багш, эцэг эх, асран хамгаалагчийн хамтын ажиллагаа,үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн, хүүхэд бүрийн хөгжил, төлөвшилд ахиц гаргана.

***ЗОРИЛТ:*** Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр, хэрэгжүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлэн, өөрийн онцлог, хэрэгцээ, шаардлагыг тусгасан үзэл баримтлалд тулгуурлан хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж ажиллана.

- Сургалтын үйл ажиллагааг гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үед тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж,онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд танхимын бус сургалтыг ТВ-ээр үзэх ажлыг зохион байгуулах.

- Багш нарыг тасралтгүй хөгжих, нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллах нөхцөл боломжоор хангахад дэмжлэг үзүүлэх, ажилтан албан хаагчдын ёс зүй харилцааны хэм хэмжээг мөрдөж , үйлчилгээний чанарыг эрхэмлэн ажиллана.

- Сургалтын байгууллагын орчны стандартыг мөрдлөг болгон, эрсдэлийн үнэлгээ хийж, аюулгүй байдлыг хангаан эрүүл ахуйн зөв дадал, хэвшил эзэмшүүлнэ.

- Байгууллагын менежментийг сайжруулан, хүүхдийн хөгжил хамгааллын асуудлаар эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах гэрээ байгуулж тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлнэ.

-Хүүхдийн бүхий л талын хөгжлийг дэмжих болон сургалтын байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах зэрэг аливаа шинэлэг санал санаачилгыг дэмжин ажиллах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

24 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

24 дүгээр цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны эхний хагас жилийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогын 246,780.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,467.8 мянган төгрөгөөр тооцсон ба гүйцэтгэлийн үе шатанд хувь хэмжээг өөрчлөөгүй бөгөөд нийт орлогын дүн жилийн дүн тул 434,503.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,345.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тогтоолоо.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

24 дүгээр цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх бараа материал өмнөх оноос 1,664.1 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар өссөн байна. Энэ нь “Ковид-19” цар тахлын үед цэцэрлэгийн зогссонтой холбоотой байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| **Мөнгөн хөрөнгө** | 438.3 | 338.3 | -100.0 |
| **Авлага** | 0 | 0 | 0 |
| **Урьдчилгаа** | | | |
| **Бараа материал** | 79,626.7 | 81,290.8 | 1,664.1 |
| **Үндсэн хөрөнгө** | 958,615.6 | 938,420.4 | -20,195.2 |
| Нийт хөрөнгө | **1,038,680.7** | **1,020,049.6** | **-18,631.1** |
| **Өр төлбөр** | 0 | 0 | 0 |
| **Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/** | 1,038,680.7 | 1,020,049.6 | **-18,631.1** |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 1,038,680.7 | 1,020,049.6 | **-18,631.1** |

Мөнгөн хөрөнгө данс 338.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь ахмадын сангийн дансанд байршиж байгаа мөнгөн хөрөнгө байна.

Авлагын данс эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 938,420.4 мянган төгрөг болж 20,195.2 мянган төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн данс нь үнэ төлбөргүй шилжиж ирсэн 5,248.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн бөгөөд тайлант хугацаанд 25,443.7 мянган төгрөгийн элэгдэл тооцсон байна.

Өр төлбөр данс эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,020,049.6 мянган төгрөг болж 18,631.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

24 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 20,921.4 мянган төгрөгөөр буюу 4.6 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 9,138.1 мянган төгрөгөөр буюу 2.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлууд байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 517,172.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 517,172.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 90,790.7 мянган төгрөгөөр бууруулж 426,381.7 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн, 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 426,381.7 мянган төгрөгийн төсөв батлагснаас, 404,609.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 21,772.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 416,639.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 404,400.5 мянган төгрөгийг зарцуулж 6,532.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Ахмадын сангийн дансны мөнгө түүнтэй адилтгах эхний 438.3 мянган төгрөгийн үлдэгдлээс тайлант хугацаанд 100.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмжид зарцуулж, тайлант хугацааны мөнгө түүнтэй адилтгах эцсийн үлдэгдэл 338.3 мянган төгрөг байна.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллагын 2020 оны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үзэхэд shilendans.gov.mn сайтад мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Итгэл” үзүүлсэн тул зөвлөмж хүргүүлээгүй байна.

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,586.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 575.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 3,011.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, бараа материалын анхан шатны баримтын бүрдэл хангаж ажиллах 1 зөвлөмж хүргүүлж байна.

### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын нийт 575.2 мянган төгрөгийн 1 алдаа зөрчлийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. 575.2 мянган төгрөгийн хүнсний материалыг БСУГ-т шилжүүлсэн байхад бараа материалын дэлгэрэнгүй тайланд зарцуулснаар тайлагнасныг залруулж шилжүүлсэн хэсэгт тайлагнууллаа.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 3,011.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,011.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага тогтоолоо. Үүнд:

1. Цалингийн зардлын хэмнэлтээс бүх ажилтнуудад тэнцүү 107.6 мянган төгрөг буюу нийт 3,011.7 мянган төгрөг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Төрийн албаны тухай хуулийн 51.2-д “Энэ хуулийн 51.1.1-д заасан шагнал олгох, 51.1.3-т заасан шагналд тодорхойлох болон 51.1.4-т заасан мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар, ... батална”, 57.8-д “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдэл, бусад нэмэгдэл хөлсний доод хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно” гэсэн заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.4, 4.5 дахь заалт, 2018 оны 382-р тогтоолын 2-д “Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u>Албан шаардлага хүргүүлэв.

## Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

## 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1. Зардлын данстай холбоотой асуудал*

*1.1. Илрүүлэлт:*

Бараа материалын тайлангийн орлого зарлагыг дугаарладаггүй. Сангийн сайдын 347 дугаар тушаалын маягтаар хөтлөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн нөхөх заавар"-ын 1-д "анхан шатны баримт гэж ажил гүйлгээ гарсныг нотолж бичгээр бүрдүүлсэн болон бусад нотолгоог хэлнэ. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. Аж ахуй нэгж, байгууллага дотооддоо мөрдөх баримт, маягтыг энэ зааварт нийцүүлнэ. Аж ахуйн нэгж, байгууллага нь анхан шатны маягтуудыг нэгдсэн журмаар урьдчилан дугаарлана." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*1.2. Эрсдэл:*

Холбогдох хууль тогтоомж зөрчих.

*1.3. Өгсөн зөвлөмж:*

Сангийн сайдын 347 дугаар тушаалыг мөрдөж ажиллах.

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Төсвийн захирагчийн 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 15 дугаар албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**ХЯНАСАН:**

**ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:** **Ц.НАРМАНДАХ**

**АУДИТЫН МЕНЕЖЕР:** **Б.ЭРДЭНЭ**

**БЭЛТГЭСЭН:**

**АУДИТОР:** **Б.БЯМБАТОГТОХ**

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1. Зардлын данстай холбоотой асуудал*

*1.1. Илрүүлэлт:*

Бараа материалын тайлангийн орлого зарлагыг дугаарладаггүй. Сангийн сайдын 347 дугаар тушаалын маягтаар хөтлөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн нөхөх заавар"-ын 1-д "анхан шатны баримт гэж ажил гүйлгээ гарсныг нотолж бичгээр бүрдүүлсэн болон бусад нотолгоог хэлнэ. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. Аж ахуй нэгж, байгууллага дотооддоо мөрдөх баримт, маягтыг энэ зааварт нийцүүлнэ. Аж ахуйн нэгж, байгууллага нь анхан шатны маягтуудыг нэгдсэн журмаар урьдчилан дугаарлана." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*1.2. Эрсдэл:*

Холбогдох хууль тогтоомж зөрчих.

*1.3. Өгсөн зөвлөмж:*

Сангийн сайдын 347 дугаар тушаалыг мөрдөж ажиллах.

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Төсвийн захирагчийн 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 15 дугаар албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**ХЯНАСАН:**

**ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:** **Ц.НАРМАНДАХ**

**АУДИТЫН МЕНЕЖЕР:** **Б.ЭРДЭНЭ**

**БЭЛТГЭСЭН:**

**АУДИТОР:** **Б.БЯМБАТОГТОХ**

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

**Огноо:** 2021.02.25 **Аудитын код:** ОРА-2021/92/СТА-ТШ3

**Аудитын нэр:** Орхон аймгийн 24 дүгээр цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

**Шалгагдсан байгууллагын нэр:** Орхон аймгийн 24 дүгээр цэцэрлэг

(мянган төгрөг)

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Цалингийн зардлын хэмнэлтээс бүх ажилтнуудад тэнцүү 107.6 мянган төгрөг буюу нийт 3,011.7 мянган төгрөг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. | 3,011.7 | Албан шаардлага өгөх | Эрхлэгч, Нягтлан бодогч | Ж,Даваасүрэн, А.Оюунчимэг |
| 2 | Бараа материалын тайлангийн орлого зарлагыг дугаарладаггүй. Сангийн сайдын 347 дугаар тушаалын маягтаар хөтлөөгүй байна. | 0 | Зөвлөмж өгөх | Эрхлэгч, Нягтлан бодогч | Ж,Даваасүрэн, А.Оюунчимэг |
| **ДҮН** | | **3,011.7** | | | |

Бэлтгэсэн: Аудитор Б.Бямбатогтох

Анхан шатанд хянасан:Аудитын менежер Б.Эрдэнэ

Хоёр дахь шатанд хянасан:Дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах

137

Орхон аймгийн 24 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

**Огноо:** 2021.02.25 **Аудитын код:** ОРА-2021/92/СТА-ТШЗ

**Аудитын нэр:** Орхон аймгийн 24 дүгээр цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

**Шалгагдсан байгууллагын нэр:** Орхон аймгийн 24 дүгээр цэцэрлэг

(мянган төгрөг)

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Цалингийн зардлын хэмнэлтээс бүх ажилтнуудад тэнцүү 107.6 мянган төгрөг буюу нийт 3,011.7 мянган төгрөг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. | 3,011.7 | Албан шаардлага өгөх | Эрхлэгч, Нягтлан бодогч | Ж.Даваасүрэн, А.Оюунчимэг |
| 2 | Бараа материалын тайлангийн орлого зарлагыг дугаарладаггүй. Сангийн сайдын 347 дугаар тушаалын маягтаар хөтлөөгүй байна. | 0 | Зөвлөмж өгөх | Эрхлэгч, Нягтлан бодогч | Ж.Даваасүрэн, А.Оюунчимэг |
| | ДҮН | 3,011.7 | | | |

Бэлтгэсэн: Аудитор Б.Бямбатогтох

Анхан шатанд хянасан:Аудитын менежер Б.Эрдэнэ

Хоёр дахь шатанд хянасан:Дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах